ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/128/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

“Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох

Утас: 9904 2814

Цахим хаяг: buyanaa99042824@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга........8
 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан........13
 4.1 Ерөнхий зүйл ........13
 4.2 Материаллаг байдал ........14
 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........14
 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........14
 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........15
 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........16
5. Аудитын илрүүлэлт ........16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 76

танай __________-ны № __________-т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
НЭГДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ЦЭРЭННАДМИД-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 74 ажил гүйцэтгэхээр төлөвлөж, хэрэгжилт 96 хувьтай байна. Тухайлбал: Сургуулийн нэгдсэн үйл ажиллагаа, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг чанаржуулах, сурагчдын суралцах хүсэл зорилгыг нэмэгдүүлэх, хандлага төлөвшлийг сайжруулах зорилгоор "Сургуулийн менежментийг сайжруулах-Шинэ Монгол" төслийг амжилттай хэрэгжүүлэн, төслийн шалгаруулалтаар 1 дүгээр байрт шалгарч, дараагийн шатны 20 сургуулийн нэгээр шалгарсан байна.

Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны материалыг 519.5 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуульд 2024 онд улсын

хөрөнгө оруулалтаар 387,006.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Хөл бөмбөг"-талбайг "Зост өргөө" ХХК-ийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэсэн байна. Мөн аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 45,000.0 мянган төгрөгийн "Grand starex" автобусыг хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| ДАНС | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **229,741,365.20** | **256,203,455.60** |
| 1 | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **141,699,764.50** | **123,733,209.90** |
| 31 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 141,699,764.50 | 123,733,209.90 |
| 312 | Төгрөг | 141,699,764.50 | 123,733,209.90 |
| 3121 | Төрийн сангийн харилцах | 141,699,764.50 | 123,733,209.90 |
| 31211 | БАРАА МАТЕРИАЛ | 88,041,600.70 | 132,470,245.70 |
| 35 | Түүхий эд материал | 27,466,208.10 | 68,742,543.10 |
| 351 | Тусгай зориулалттай материал | 26,383,474.00 | 67,329,809.00 |
| 35110 | Эм боох материал | 1,082,734.10 | 1,412,734.10 |
| 35130 | Хангамжийн материал | 60,575,392.60 | 63,727,702.60 |
| 354 | Бичиг хэргийн материал | 969,800.00 | 969,800.00 |
| 35410 | Аж ахуйн материал | 6,903,340.00 | 6,903,340.00 |
| 35420 | Түлш шатах тослох материал | 0.11 | 0.11 |
| 35440 | Барилгын засварын материал | 3,989,200.00 | 3,989,200.00 |
| 35450 | Хүнсний материал | 1,078,000.00 | 837,060.00 |
| 35460 | Бусад хангамжийн материал | 47,635,052.49 | 51,028,302.49 |
| **35470** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,359,703,183.44** | **4,990,612,999.41** |
| **2** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,359,703,183.44** | **4,990,612,999.41** |
| 39 | Биет хөрөнгө | 3,601,910,683.44 | 4,228,318,143.15 |
| 392 | Барилга, байгууламж | 3,734,053,365.59 | 4,110,555,318.59 |
| 39201 | Хуримтлагдсан элэгдэл | (717,136,740.84) | (864,018,601.09) |
| 39202 | Авто тээврийн хэрэгсэл | 13,500,000.00 | 58,500,000.00 |
| 39203 | Хуримтлагдсан элэгдэл | (2,700,000.00) | (5,175,000.00) |
| 39204 | Машин, тоног төхөөрөмж | 548,957,488.71 | 853,065,354.31 |
| 39205 | Хуримтлагдсан элэгдэл | (250,948,630.83) | (305,434,833.58) |
| 39206 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 339,256,927.25 | 320,950,750.86 |
| 39207 | Хуримтлагдсан элэгдэл | (168,625,318.88) | (88,223,181.55) |
| 39208 | Бусад үндсэн хөрөнгө | 48,500,725.00 | 65,380,824.60 |
| 39214 | Хуримтлагдсан элэгдэл | (30,104,069.22) | (4,439,425.65) |
| 39215 | Номын фонд | 87,156,936.66 | 87,156,936.66 |
| 39217 | Биет бус хөрөнгө | 757,792,500.00 | 762,294,856.26 |
| 393 | Програм хангамж | 2,549,500.00 | 7,657,525.00 |
| 39301 | Хасагдуулга | (1,489,500.00) | (2,095,168.74) |
| 39302 | Бусад биет бус хөрөнгө | 756,732,500.00 | 756,732,500.00 |
| 39303 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 4,589,444,548.64 | 5,246,816,455.01 |
| 3 | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **0.00** | **69,454,429.99** |
| 4 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **69,454,429.99** |
| 41 | Өглөг | 0.00 | 69,454,429.99 |
| 413 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 0.00 | - |
| 41310 | Бусад өглөг | (0.00) | 69,454,429.99 |
| 4136 | Байгууллагад төлөх өглөг | (0.00) | 69,454,429.99 |
| **41361** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **4,589,444,548.64** | **5,177,362,025.02** |
| **5** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,589,444,548.64** | **5,177,362,025.02** |
| 51 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 2,646,236,575.80 | 2,646,236,575.80 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Өмч: -Төрийн өмч | 2,646,236,575.80 | 2,646,236,575.80 |
| 51101 | Хуримтлагдсан үр дүн | 996,368,343.34 | 1,584,285,819.72 |
| 512 | Өмнөх үеийн үр дүн | 628,125,856.63 | 1,584,285,819.72 |
| 51210 | Тайлант үеийн үр дүн | | 587,917,476.38 |
| 51220 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 946,839,629.50 | 946,839,629.50 |
| 51300 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 4,589,444,548.64 | 5,246,816,455.01 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| ДАНС | Үзүүлэлт | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,860,565,943.65** | **4,982,384,240.20** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **432,787,706.15** | **865,865,540.20** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 432,787,706.15 | 865,865,540.20 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 432,787,706.15 | 865,865,540.20 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 507,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 118,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө | 428,897,458.15 | 824,811,805.20 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал | 3,772,248.00 | 40,546,335.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,427,778,237.50** | **4,116,518,700.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,005,041,200.00 | 3,664,679,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,005,041,200.00 | 3,664,679,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 16,438,337.50 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,438,337.50 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 406,298,700.00 | 451,839,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуллага/ | 406,298,700.00 | 451,839,300.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **3,492,323,456.94** | **4,394,466,763.82** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,492,323,456.94** | **4,394,466,763.82** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,338,940,856.94 | 4,274,626,145.94 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 2,233,147,277.00 | 2,888,965,582.00 |
| 210101 | Цалин | 1,356,594,224.00 | 1,751,116,890.00 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 748,860,635.00 | 967,068,726.40 |
| 210104 | Урамшуулал | 127,692,418.00 | 170,779,965.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 276,724,575.00 | 362,280,388.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 188,370,475.00 | 246,350,160.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 22,143,532.00 | 28,982,206.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 17,714,965.00 | 14,491,504.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 4,406,930.00 | 14,491,504.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 44,088,673.00 | 57,965,014.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 404,934,700.00 | 439,926,134.12 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 31,016,204.00 | 31,614,035.08 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 356,253,431.00 | 375,006,299.04 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 17,665,065.00 | 33,305,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 17,958,360.00 | 26,025,420.60 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 1,831,100.00 | 3,509,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 8,081,160.00 | 15,056,120.60 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 5,203,050.00 | 7,459,800.00 |
| 210408 | Бараа материал актасны зардал | 2,843,050.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 83,787,880.00 | 90,145,880.00 |
| 210501 | Эм | 245,690.00 | 2,172,070.00 |
| 210502 | Хоол | 83,542,190.00 | 87,973,810.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,500,000.00 | 11,913,048.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,500,000.00 | 11,913,048.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 11,752,300.00 | - |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 11,752,300.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 20,087,400.00 | 60,029,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,173,300.00 | 507,400.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 13,914,100.00 | 59,521,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 286,048,364.94 | 395,340,693.22 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,004,944.00 | 62,210,196.99 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 20,871,100.00 | 24,492,440.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 239,172,320.94 | 308,638,056.23 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 153,382,600.00 | 119,840,617.88 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 153,382,600.00 | 119,840,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 117,206,100.00 | 119,840,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 36,176,500.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 117.88 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 117.88 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 368,242,486.71 | 587,917,476.38 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 0.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | - | (0.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 368,242,486.71 | 587,917,476.38 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *(төгрөгөөр)*

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 4,117,026,100.00 | 4,117,026,100.00 |
| 1 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 507,400.00 | 507,400.00 |
| 12 | Нийтлэг татварын бус орлого | 507,400.00 | 507,400.00 |
| 120 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 507,400.00 | 507,400.00 |
| 120004 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 507,400.00 | 507,400.00 |
| 1200041 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,116,518,700.00 | 4,116,518,700.00 |
| \\\\\ | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,664,679,400.00 | 3,664,679,400.00 |
| 1310 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,664,679,400.00 | 3,664,679,400.00 |
| 131001 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 451,839,300.00 | 451,839,300.00 |
| 1320 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 451,839,300.00 | 451,839,300.00 |
| 132001 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 4,084,004,335.60 | 4,084,004,335.60 |
| 2 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,084,004,335.60 | 4,084,004,335.60 |
| 21 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,960,770,467.72 | 3,960,770,467.72 |
| 210 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 2,888,965,582.00 | 2,888,965,582.00 |
| 2101 | Үндсэн цалин | 1,751,116,890.00 | 1,751,116,890.00 |
| 210101 | Нэмэгдэл | 967,068,726.40 | 967,068,726.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Үр дүнгийн урамшуулал | 170,779,965.60 | 170,779,965.60 |
| **210104** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **362,280,388.00** | **362,280,388.00** |
| 2102 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 246,350,160.00 | 246,350,160.00 |
| 210201 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 28,982,206.00 | 28,982,206.00 |
| 210202 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 14,491,504.00 | 14,491,504.00 |
| 210203 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 14,491,504.00 | 14,491,504.00 |
| 210204 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 57,965,014.00 | 57,965,014.00 |
| **210205** | **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | **439,926,134.12** | **439,926,134.12** |
| 2103 | Гэрэл цахилгааны зардал | 31,614,035.08 | 31,614,035.08 |
| 210301 | Түлш, халаалтын зардал | 375,006,299.04 | 375,006,299.04 |
| 210302 | Цэвэр, бохир усны зардал | 33,305,800.00 | 33,305,800.00 |
| 210303 | Нормативт зардал | 87,732,870.00 | 87,732,870.00 |
| 2105 | Хоол, хүнс | 87,732,870.00 | 87,732,870.00 |
| **210502** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,913,048.00** | **11,913,048.00** |
| 2106 | Урсгал засвар | 11,913,048.00 | 11,913,048.00 |
| **210604** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **60,029,000.00** | **60,029,000.00** |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 507,400.00 | 507,400.00 |
| 210801 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 59,521,600.00 | 59,521,600.00 |
| 210806 | Бараа үйлчилгээний бусад зардал | 109,923,445.60 | 109,923,445.60 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 85,031,005.60 | 85,031,005.60 |
| 210901 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,892,440.00 | 24,892,440.00 |
| **210902** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **123,233,867.88** | **123,233,867.88** |
| 213 | Бусад урсгал шилжүүлэг | 123,233,750.00 | 123,233,750.00 |
| 2132 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 123,233,750.00 | 123,233,750.00 |
| 213205 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 117.88 | 117.88 |
| 2134 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 117.88 | 117.88 |
| **213403** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **33,021,764.40** | **33,021,764.40** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **50,988,319.00** | **50,988,319.00** |
| **5** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **50,988,319.00** | **50,988,319.00** |
| 22 | Дотоод эх үүсвэрээр | 50,988,319.00 | 50,988,319.00 |
| 2200 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 50,988,319.00 | 50,988,319.00 |
| **225106** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(50,988,319.00)** | **(50,988,319.00)** |
| | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(17,966,554.60)** | **(17,966,554.60)** |
| 8 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 141,699,764.50 | 141,699,764.50 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 123,733,209.90 | 123,733,209.90 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *(төгрөгөөр)*

/төгрөгөөр/

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 2 | 2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 1,275,041,075.80 | 23,132,840.00 | 3,364,551,553.30 | 4,662,725,469.10 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,275,041,075.80 | 23,132,840.00 | 3,364,551,553.30 | 4,662,725,469.10 |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | | (218,771,526.40) | (218,771,526.40) |
| 9 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 2,646,236,575.80 | 946,839,629.50 | 996,368,343.30 | 4,589,444,548.60 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 2,646,236,575.80 | 946,839,629.50 | 996,368,343.30 | 4,589,444,548.60 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,646,236,575.80 | 946,839,629.50 | 996,368,343.30 | 4,589,444,548.60 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | | 587,917,476.30 | 587,917,476.30 |
| 18 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 2,646,236,575.80 | 946,839,629.50 | 1,584,285,819.70 | 5,177,362,025.00 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *⁄төгрөгөөр⁄*

| | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 141,699,764.50 | (141,699,764.50) |
| 2 | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,805,533,400.00** | **3,683,153,354.60** | **122,380,045.40** |
| 3 | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **3,805,533,400.00** | **3,683,153,354.60** | **122,380,045.40** |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 3,682,299,500.00 | 3,559,919,604.60 | 122,379,895.40 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,990,291,800.00 | 2,888,965,582.00 | 101,326,218.00 |
| 6 | Үндсэн цалин | 1,886,343,900.00 | 1,751,116,890.00 | 135,227,010.00 |
| 7 | Нэмэгдэл | 974,650,300.00 | 967,068,726.40 | 7,581,573.60 |
| 9 | Урамшуулал | 129,297,600.00 | 170,779,965.60 | (41,482,365.60) |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 373,786,700.00 | 362,280,388.00 | 11,506,312.00 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 254,174,800.00 | 246,350,160.00 | 7,824,640.00 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 29,902,900.00 | 28,982,206.00 | 920,694.00 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 14,951,600.00 | 14,491,504.00 | 460,096.00 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 14,951,600.00 | 14,491,504.00 | 460,096.00 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 59,805,800.00 | 57,965,014.00 | 1,840,786.00 |
| 30 | Нормативт зардал | 94,888,200.00 | 87,732,870.00 | 7,155,330.00 |
| 32 | Хоол, хүнс | 94,888,200.00 | 87,732,870.00 | 7,155,330.00 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 61,502,800.00 | 61,502,800.00 | - |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 507,400.00 | 507,400.00 | - |
| 49 | Мэдээллийн технологийн зардал | 60,995,400.00 | 60,995,400.00 | - |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 161,830,000.00 | 159,437,964.60 | 2,392,035.40 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 136,936,800.00 | 134,545,524.60 | 2,391,275.40 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,893,200.00 | 24,892,440.00 | 760.00 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 123,233,900.00 | 123,233,750.00 | 150.00 |
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | 123,233,900.00 | 123,233,750.00 | 150.00 |
| 74 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 123,233,900.00 | 123,233,750.00 | 150.00 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,665,186,800.00 | 3,665,186,800.00 | - |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,664,679,400.00 | 3,664,679,400.00 | - |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 3,664,679,400.00 | 3,664,679,400.00 | - |
| 120 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 507,400.00 | 507,400.00 | - |
| 125 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 507,400.00 | 507,400.00 | - |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 141,699,764.50 | (141,699,764.50) |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 123,733,209.90 | (123,733,209.90) |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн |
|---|---|---|---|---|
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **451,839,300.00** | **451,839,182.12** | **117.88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **451,839,300.00** | **451,839,182.12** | **117.88** |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 451,839,300.00 | 451,839,182.12 | 117.88 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 439,926,200.00 | 439,926,134.12 | 65.88 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 30,328,500.00 | 31,614,035.08 | -1,285,535.08 |
| 210302 | Түлш, халаалт | 372,843,700.00 | 375,006,299.04 | -2,162,599.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 36,754,000.00 | 33,305,800.00 | 3,448,200.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 11,913,100.00 | 11,913,048.00 | 52 |
| 210604 | Урсгал засвар | 11,913,100.00 | 11,913,048.00 | 52 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **451,839,300.00** | **451,839,300.00** | **-** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **451,839,300.00** | **451,839,300.00** | **-** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 451,839,300.00 | 451,839,300.00 | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн үйл ажиллагааны чиглэл:*** Хүүхэд бүрийн сурч хөгжих, эрүүл зөв амьдрах дадал, үйлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгаж, суралцах тэгш боломжийг бүрдүүлэн, хичээл сургалтын үйл ажиллагаанд бүх талын хамтын оролцоог дэмжих, багш ажилтны ёс зүй, өөрийн удирдлагатай суралцахуй, багшлахуйг эрхэмлэн хөгжүүлэх замаар сургалт, үйл ажиллагааны чанарт ахиц гаргахаар зорилго тавин ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Боловсролын ерөнхий хууль
2. Төрийн хэмнэлтийн тухай хууль
3. Төрийн албаны тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Төрийн хэмнэлтийн тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль
12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус сургууль нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 657,371.9 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар өссөн.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | | | |
| Бараа материал | 88,041.6 | 132,470.2 | 44,428.6 |
| Үндсэн хөрөнгө | 4,359,703.1 | 4,990,612.9 | 630,909.8 |
| **Нийт хөрөнгө** | **4,589,444.5** | **5,246,816.4** | **657,371.9** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,646236.5 | 2,646236.5 | 0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **4,589,444.5** | **5,246,816.4** | **657,371.9** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын үлдэгдэлгүй, бараа материалын эхний үлдэгдэл 88,041.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 348,493.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 40,546.3 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 344,611.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 132,470.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 44,428.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд 501,742.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 363,456.9 мянган төгрөгийн бусад тоног төхөөрөмжийг орлогод авч, 49,813.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, жилийн эцэст 4,990,612.9 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 308,638.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 2,646,236.5 мянган төгрөг тайлант онд өөрчлөлт ороогүй болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,805,533.4 мянган төгрөг, нийт зарлагыг 3,805,533.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,541,453.8 мянган төгрөгийг улсын төсвөөс олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,665,186.8 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байна. Энэ нь цалин, НДШ-ийн зардлын зардал 101,326.2 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал, 7.155.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71802 | Ерөнхий боловсрол | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 80217 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 4,502.9 | 0 | 4,502.9 | 0.0 |
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 6,140.4 | 6,140.4 | 0 | 100.0 |
| 80233 | Хүүхэд хамгаалал | 6,508.6 | 6,508.6 | 0 | 100.0 |
| 80312 | Сургалт семинар | 4,471.2 | 4,465.39 | 5.81 | 99.9 |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 123,233.9 | 123,233.75 | 0.15 | 100.0 |
| 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 387,458.6 | 387,458.6 | 0 | 100.0 |
| 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 53,667.2 | 53,667.2 | 0.08 | 100.0 |
| 81823 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 18,421.0 | 18,421.0 | 0 | 100.0 |
| 81827 | Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 20,740.3 | 20740.3 | 0 | 100.0 |
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын | 2,881,255.1 | 2,768,523.44 | 112,731.66 | 96.1 |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 138,796.0 | 138,796.0 | 0 | 100.0 |
| 81848 | Сурах бичгийн түрээс | 7,000.0 | 507.4 | 6,492.6 | 7.2 |
| 81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 12,991.6 | 12,991.6 | 0 | 100.0 |
| **НИЙТ** | | **3,665,186.8** | **3,541,453.5** | **123,733.2** | **96.6** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

***Хүснэгт 3. Нэмэлт төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл***

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71802 | Ерөнхий боловсрол | | | | |
| 80109 | ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал | 451,839.3 | 451,839.1 | 0.11 | 100.0 |
| НИЙТ | | **451839.3** | **451839.1** | **0.11** | **100.0** |

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 451,839.3 мянган төгрөгийн тогтмол зардал төвлөрүүлж, батлагдсан төсвийн дагуу 451,839.1 мянган төгрөгийг зарцуулж, 0.11 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 *Хүснэгт 4* Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөгөөр/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Харьцуулалтын арга | Үдийн цай | 123,233.9 | 123,233.7 |
| 2 | Шууд гэрээ байгуулах | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал | 61,502.8 | 61,502.8 |
| 3 | Шууд гэрээ байгуулах | Гэрэл цахилгааны зардал | 30,328.5 | 31,614.0 |
| 4 | Шууд гэрээ байгуулах | Түлш халаалтын зардал | 372,843.7 | 375,006.2 |
| 5 | Шууд гэрээ байгуулах | Цэвэр бохир усны зардал | 36,754.0 | 33,305.8 |
| 6 | Шууд гэрээ байгуулах | Урсгал засварын зардал | 11,913.1 | 11,913.0 |
| 7 | Шууд гэрээ байгуулах | Бараа үйлчилгээний бусад зардал | 161,830.0 | 159,437.9 |
| 8 | Шууд гэрээ байгуулах | Хоол | 94,888.2 | 87,732.8 |
| **ДҮН** | | | **893,294.4** | **852,132.2** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн анхан шатанд хянаж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт 3,860,565.9 мянган төгрөгийн орлогын дүнгээс 1 хувиар буюу 38.605.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 30,884.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт 4,982,384.2 мянган төгрөгийн орлогын дүнгээс 1 хувиар буюу 49,823.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 39,859.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ур чадварын нэмэгдэл тушаалгүйгээр олгосон 1,264.0 мянган төгрөгийн зөрчилд тогтоосон актыг 100% барагдуулж ажилласан байна.

***Хүснэгт 5*** *Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,264.0 | 1 | 1,264.0 | 100% |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **1,264.0** | **1** | **1,264.0** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,455.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 5,935.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 519.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

***Залруулсан алдаа:*** Интернэтийн төлбөр, томилолтын зардлыг аккруэл суурьар хөтлөөгүй, шууд зардалд тайлагнасан, , худалдаж авсан бараа материалыг хөрөнгийг зардалд тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтлөж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасан, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан " "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам""-тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### 5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 5.2 Албан шаардлага өгөгдөөгүй

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***Илрүүлэлт:*** Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нормативаас 227.4 мянган төгрөгөөр, үдийн цайны зардлыг 292.1 мянган төгрөгөөр тус тус илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах’, Засгийн газрын 2022 оны 498 дугаар тоот тогтоолын 2-д “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах ахлах ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4300 (дөрвөн мянга гурван зуун) төгрөгөөр, бага, дунд ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4000 (дөрвөн мянган) төгрөгөөр тус тус тогтоосугай” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дотуур байрны хүүхдийн хоол болон үдийн цайны зардлыг нормативаас хэтрүүлэн зарцуулахгүй байх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн 519.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Интернетийн төлбөр, томилолтын зардлыг аккруэл сууриар хэтлээгүй, шууд зардалд тайлагнасан. | 1 | 3,210.7 | | | 1 | 3,210.7 | 1 | 3,210.7 | | | | |
| Бага үнэтэй хөрөнгийг зардалд бичсэн | 1 | 2,725.0 | | | 1 | 2,725.0 | 1 | 2,725.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **5,935.7** | | | **2** | **5,935.7** | **2** | **5935.7** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нормативаас 227.4 мянган төгрөгөөр, үдийн цайны зардлыг 292.1 мянган төгрөгөөр тус тус илүү олгосон | 1 | 519.5 | | | | | 1 | 519.5 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **519.5** | | | | | **1** | **519.5** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-24

**БОЛОВСРУУЛСАН:**

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ж.БУЯНТОГТОХ

Огноо: 2025-02-24